

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015.04.30

дугаар 01


Шарын гол

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
ТУЗ-ийн ажлын тайлангийн тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 онд хийсэн ажлыг хангалттай гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015.04.30

дугаар 02

Шарын гол

*Олон нийтэд санал болгосон үнэт
цааснаас арилжаалагдаагүй хувьцааг
хасах тухай*

Компанийн тухай хуулийн 17, 76 дугаар зүйл, компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолоор олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаалагдаагүй үлдсэн 61.147 ширхэг энгийн хувьцааг хасахаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн компанийн дүрмийн 4-ийн 2 дахь заалтыг “компани нь нэг бүр 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,170,242 (Арван сая нэг зуун далан мянга хоёр зуун дөчин хоёр) ширхэг энгийн хувьцаа (цаашид “Хувьцаа” гэх) гаргах эрхтэй гэж өөрчилсүгэй.
3. Хасагдаж буй хувьцааг зохих журмын дагуу холбогдох байгууллагуудад бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015.04.30

дугаар 03

Шарын гол

*Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2015 оны зардлын төсвийн тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн удирдлагын зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2015.04.30

дугаар 04

Шарын гол

*Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
ердийн болон хараат бус гишүүдийг
сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 8.3 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд

- Б.Батмөнх
- Б.Батбаатар
- Ж.Батболд
- Грам Чапман
- Д.Даянбилгүүн
- Жеймс Пассин

Хараат бус гишүүд

- Д.Байлхүү
- Жозеф Найэми
- Кеннет Фаррелл нарыг

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хжрал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ